

Батлав: "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Б.Дүгэржав

2024 оны санхүүгийн аудитын тайлангаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал

6/30/2025

№	Алдаа зөрчлийн товч утга	Өгсөн зөвлөмж	Мөнгөн дүн /сая төгрөг/	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Харуулах газар, хэлтэс	Хэрэгжилт
1	Тайлант оны 12 дугаар сард туршилтын хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулсан, бүтэн улирал ажиллаагүй 16 ажилтан, хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй 4 ажилтанд нийт 14.4 сая төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Хэмнэлтийн бусад арга хэмжээ. 15.2.6. байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.	14,438.00	Илүү олгосон 14.4 сая төгрөгийн урамшуулалт цалинг холбогдох ажилтнуудаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх	2025.06.30	ЗУГ Энхтүвшин, Бямбажаргал, СТГ Шүрэнцэцэг, Бадамдорж	Холбогдох албан тушаалтнуудаар төлүүлж улсын төсөвт төвлөрүүлсэн.
1	Компаний хөдөлмөрийн дотоод журмыг зөрчин, сахилгын шийтгэлтэй 50 ажилтанд гүйцэтгэх захирлын тушаалаар 290.3 сая төгрөгийн улирлын болон жилийн эцсийн урамшуулалт цалинг олгосон.	Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.1.5-д зааснаар хөдөлмөрийн сахилга, шийтгэлийг давхардуулан олгохгүй бөгөөд сахилгын шийтгэлтэй хугацаанд шагнал урамшуулал олгохгүй. 9.1.6.Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсанаас хойш 1 жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно.	290,349.30	Ажилтануудад ажлын гүйцэтгэл, үр дүн, сахилгын шийтгэлтэй эсэхийг үл харгалзан тухайн сахилгын шийтгэлтэй хугацаанд урамшуулал олгож байгаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх	2025.06.30	ЗЭЗХ Очхүү, ЗУГ Энхтүвшин, Бямбажаргал, СТГ Бадамдорж	2025 онд урамшуулалт цалин олгоогүй болно. /Сахилгын шийтгэлтэй ажиллагсдын тушаал, цалингийн хүснэгт/
2	Тус компаний хөрөнгөд бүртгэлтэй Гэрэгз оффисын барилгыг "Монголын төмөр зам" ТӨХК-д үнэ төлбөргүй ашиглуулж, уг хөрөнгөтэй холбоотой ашиглалт болон хөрөнгийн удирдлагын менежментийн 23.5 сая төгрөгийн зардлыг тайлант хугацааны зардлаар бүртгэж тайлагнасан.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1."Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлад өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", 67.2 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.	23,531.40	Гэрэгз оффисын барилгыг үнэ төлбөргүй ашиглуулж байгааг зогсоож, хуулийн дагуу түрээсийн гэрээгээр эзэмшүүлж, төлбөртэй ашиглуулах.	2025.06.30	СТГ Г.Шүрэнцэцэг, ЗУГ Ч.Батцэнгэл, Лхагва-Очир	ЗЭЗХ түрээсийн гэрээ байгуулах
3	Компаний зорилтот түвшний төлөвлөгөөгөөр ачаа тээврийн төлөвлөгөө тасарсан байхад тээвэрлэлтийн үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан гэж Тээврийн удирдлагын газрын ажилтнуудад жилийн эцсийн урамшуулалд 42.1 сая төгрөг олгосон.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Хэмнэлтийн бусад арга хэмжээ. 15.2.6. байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.	42,133.50	Шагнал урамшууллыг олгохдоо ажлын үр дүн гүйцэтгэлтэй уялдуулахгүй олгож байгаа зөрчлийг арилгах.	2025.06.30	ЗЭЗХ Очхүү, ЗУГ Энхтүвшин, Бямбажаргал	Тайлбар авах, дахин давтахгүй байх.
4	Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК болон Монголросцветмет ТӨҮГ-т төлбөртэйгээр түрээслүүлж байсан 250 вагоныг өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын албан бичгийн дагуу буцаан авч гэрээг цуцлан, УБТЗ ХНН-д 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн ТҮГ-2024/30 тоот гэрээний дагуу үнэ төлбөргүй ашиглуулснаас өмнө нь мөрдөж байсан тарифаар тооцоход 2,800.0 сая төгрөгийн түрээсийн орлого олох боломжийг алдсан. Уг хөрөнгийн элэгдэл нь борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэгдэж байгаа зэргээс шалтгаалж компаний орлого, үр дүн бодит бус илэрхийлэгдэж байна	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1.Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.	2,800,000.00	Компанийн хөрөнгийг зохих байгууллагын шийдвэрээр бусдад ашиглуулах шаардлага гарсан ч компанийн үр ашгийг бууруулахгүй байдлаар зохион байгуулах	2025.06.30	ТУГ Батбаяр, СТГ Батжаргал, Дэлгэрхишиг, Н Заяа	Салбар яам болон Төрийн өмчит байгууллагууд хоорондоо хөрөнгө түрээслэх асуудлыг хуульд өөрчлөлт оруулах санал хүргэх

	Төслийн гүйцэтгэлд олон улсын аудитын байгууллагын гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээний тайлантай ТУЗ танилцаж, өгсөн зөвлөмжийг хүлээн авч бүртгэлд тусгах талаар зохих шийдвэрээ гаргаагүй байна. Төслийн явц дундын гүйцэтгэлийг санхүүгийн тайланд бүрэн тусгаж ажиллах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна."		Олон улсын аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг ТУЗ-аар хэлэлцүүлж, зохих шийдвэрийг гаргах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах	2025.06.30	СТГ Э.Амарсайхан, Ч.Чандалноров	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авахыг даалгасан. Тус тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн "Бодь Интернэшнл" ХХК-аар гүйцэтгүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэж тусгах ажил хийгдэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолын 5 дугаар заалт, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолын 3 дугаар заалт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ӨХБ3/02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/58 дугаар тушаал гарч Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг компанийн нягтлан бодох бүртгэлд бүртгэх зөвшөөрөл өгсний дагуу нийт 1348 нэрийн 2,393,915,032,200.60 (хоёр ихнайд гурван зуун ерэн гурван тэрбум есөн зуун арван таван сая гучин хоёр мянга хоёр зуун төгрөг жаран мөнгө) төгрөгийн хөрөнгийг санхүүгийн
2	Газар эзэмших эрхүүдийг нийт дүнгээр бүртгэснийг талбар нэгж бүрээр бүртгэх өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хувьцаа эзэмшигчээс хөрөнгө оруулсан 7,400.6 сая төгрөгийн өртөг бүхий газар эзэмших эрх хүчингүй болж, улсын бүртгэлийн лавлагаагаар баталгаажуулаагүй байна.	Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна	7,400,642.80	Газар эзэмших эрхийг нийт дүнгээр бүртгэсэн зөрчлийг арилгах. Газар эзэмших эрхийг талбар нэгж бүрээр салгах.	2025.06.30	СТГ Э.Дуламсүрэн, Н.Заяа	2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 1/2049 дугаартай албан бичгээр Өмнөговь аймгийн Засаг даргад гомдол гаргасан боловч Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.3 дахь хэсэгт заасан хугацаанд буюу 30 хоногийн дотор шийдвэрлэж, хариу ирүүлээгүй болно. Улмаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр 1/2429 дугаартай албан бичгээр нэхэмжлэл гаргасан. Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024.11.21-ний өдрийн 0205 дугаартай "Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох тухай" захирамжийн дагуу 2024.12.05-ны өдөр 1/3035 дугаартай албан бичгээр нэхэмжлэлийн шаардлагын тодруулга, тайлбарыг хүргүүлсэн. Өмнөговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 0215 дугаартай захирамжаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан. Улмаас тус захирамжид "нэхэмжлэгч нь урьдчилан шийдвэрлэх журмаар гаргасан гомдлыг хүлээж аваагүй хэлбэрийн төдий шалтгааныг арилгаж дахин Өмнөговь аймгийн Засаг даргад хандаж гомдол гаргах боломжтой байна" гэж дурдсаны дагуу 2024.12.25-ны өдөр 1/3219
	Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 6.0 сая тонн ачаа тээвэрлэхээс гүйцэтгэлээр 4.1 сая тонн ачааг тээвэрлэж, төлөвлөсөн хэмжээний ачааг тээвэрлээгүйгээс ачаа тээврийн орлогын төлөвлөгөө 61,690.1 сая төгрөгөөр тасарсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"	61,690,100.00	Компанийн зорилтот түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах	2025.06.30	СТГ Монхчимс, ТУГ Батбаяр	2024 онд нийт 6,0 сая тонн ачаа тээвэрлэх төлөвлөгөөтэй. 2024 онд Ачилтын тайлангаар 3,909.08 мян.тн, буулгалтын тайлангаар 1,972.58 мян.тн, тээвэрлэлтийн тайлангаар 4,156.77 мян.тн ачаа тээвэрлэсэн нь 69.28 хувийн биелэлттэй байна
4	Тайлант хугацааны эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй томоохон харилцагч байгууллагаас авах нийт 768.0 сая төгрөгийн авлагыг баталгаажуулахаар захидал илгээсэн ч үлдэгдэл тохирохгүй учир баталгаажуулах боломжгүй гэсэн хариуг шалгагдагч байгууллагаас өгсөн тул санхүүгийн тайлангаар зарим авлагын дүн бодитой эсэх нь нотлогдохгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"	768,000.00	Харилцагч бүртэй авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулан тооцоо нийлж, баталгаажуулах зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх.	2025.06.30	СТГ Батжаргал, Дэлгэрхишиг	"Монголросцветмет" ХХК-аас авах 664.7 сая төгрөгийн авлага барагдсан болно. "Бодь Интернэшнл" ХХК руу 103.3 сая төгрөгийн авлагын тооцоо хийлэх акт удаа дараа явуулж байгаа боловч хариу ирүүлээгүй болно.

							Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авахыг даалгасны дагуу тус тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн а/29 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисст орж компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн тооллогын ажлыг Өмнөговь аймаг Баян-овоо, Цогтцэций, Ханбогд суманд байрлалтай кепл, өртөө, төв оффисийн байрлалд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 02-ны өдрийг дуустал явууллаа. Тайланг бичиж үр дүнг тайлагнаж архивын нэгж үүсгэсэн. "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/82, А/48 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг хамтарч тоолж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Тооллогын комисс нь компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн тооллогын ажлыг Өмнөговь аймаг Баян-овоо, Цогтцэций, Ханбогд суманд байрлалтай кепл, өртөө байрлалд 2025 оны 04
1	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогод зөвхөн төв оффисын бараа материал, үндсэн хөрөнгийг хамруулан тоолж, орон нутагт байрлах кеплийн болон өртөөнүүдийн агуулахыг хамруулаагүй	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 "Тооллогын комисс дараахь үүрэгтэй": 72.4.1" эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах"		Компаний эзэмшилд байгаа хөрөнгийн биет хяналтыг хэрэгжүүлэх, тооллогыг хуулийн дагуу цаг тухайд нь хийх.	2025.06.30	СТГ Э.Амарсайхан, Э.Дуламсүрэн, Ч.Чанцалноров, Н.Заяа	
2	"Монголын төмөр заму ТӨХК –аас авах 1,218.5 сая төгрөгийн алданги, Улаанбаатар төмөр зам ХНН-ээс авах 3.5 сая төгрөгийн алданги, нийт 1,222.0 сая төгрөгийн гэрээний алдангийн төлбөрийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"	1,222,008.10	Гэрээний дагуу төлөгдөөгүй авлагад ногдох алдангийг бүртгэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулах	2025.06.30	СТГ Батжаргал, Дэлгэрхишиг	"Монголын төмөр заму ТӨХК болон Улаанбаатар төмөр зам ХНН-руу алданги оруулсан дүнтэй авлагаа барагдуулахыг хүссэн албан бичиг удаа дараа явуулж байгаа боловч хариу ирүүлээгүй болно
1	Тайлант онд нийт 7 байгууллагатай хийсэн ачаа тээврийн гэрээний дагуу 556.0 сая төгрөгийг вагон пүүний орлогод бүртгэсэн. ЭТТ ХХК 2023 оноос эхлэн вагон пүүний төлбөрийг төлөөгүй, 2024 онд байгуулах гэрээнд энэ тухай тусгах нь зүйтэй гэж хууль зүйн дүгнэлт гарсан ч тайлант онд байгуулсан 2 гэрээнд вагон пүүтэй холбоотой асуудлыг дурдаагүйгээс ЭТТ ХК-аас авах вагон пүүний 475.4 сая төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй.	Компаний дүрмийн 9.5-д зааснаар Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуульд зааснаас гадна гадна дор дурдсан эрх эдэлж үүрэг хүлээнэ. 9.5.3 Компанийн нэр хүнд ашиг, орлого, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, санхүү болон бусад үйл ажиллагааг алдагдал, эрсдэл орохоос урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн удирдлагын оновчтой менежментийг нэвтрүүлэх.	475,400.00	Вагон пүүний орлогыг тээвэрлүүлэгч компанитай хийгдсэн гэрээнд тодорхой тусгасны үндсэн дээр бүрэн төвлөрүүлэх. Эрдэнэс тавантолгой ХК-тай байгуулсан гэрээнд тодорхой тусгаж өгөх	2025.06.30	ТУГ Батбаяр, СТГ Батжаргал, Дэлгэрхишиг,	ЭТТ ХК-тай 2023 онд байгуулсан гэрээнд вагон пүүний төлбөрийг тусгаагүй ба ЭТТ ХК-аас пүүлэлт давхардаж байгаа тул пүүний төлбөр нэмж төлөх боломжгүй гэв. 2024 онд байгуулсан гэрээ нь өмнөх гэрээний сунгалтаар хийгдсэн ба дахин шинэ гэрээ хийгдээгүй байгаа болно
2	Зорилтот түвшний тайлангийн үзүүлэлт бүрийг шинжилж үзвэл материаллаг хэмжээний зөрүү болох ерөнхий удирдлагын зардлыг 1,540.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлийг 10,293.8 сая төгрөгөөр тайлагнаж, 8,753.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь төлөвлөгөө гүйцэтгэлийн зэрэгцүүлэх мэдээллийг үнэн зөв төлөвлөж, тайлагнаагүй	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"		Зардлыг компанийн бүтэц зохион байгуулалттай уялдуулан, өргийн төв болон зардлын гүйцэтгэлийг бодитоор тооцож төлөвлөх, нэгдэлт батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлын гүйцэтгэлийг тайлагнах талаар НБББББ-т тодорхой тусган үнэн зөв, төлөвлөж тайлагнаж байх	2025.06.30	СТГ Мөнхчигэг, СТГ Батжаргал	2024 оны санхүүгийн аудитын тайлангаар өгөгдсөн чиг үүргийн дагуу Төлөвлөлтийн хэлтэс нь хууль журмын дагуу компанийн ЭЗҮҮЭТ-ийг үнэн зөв, үр ашгтай байхаар боловсруулж байгаа бөгөөд ТУЗ-ийн 2025 оны 13 дугаар "компанийн бүтэц шинэчлэн батлах тухай" тогтоол болон ЭТТ ХК-иас хөрөнгө түрээслэх гэрээтэй холбоотойгоор ирүүлсэн хууль зүйн дүгнэлтүүдээс хамаарч зарим зардлын санхүүгийн анхан шатны баримт бүрдэх хугацаа бүрдээгүйгээс хамаарч 2025 оны 07-р сарын 01-ний өдрийн байдлаар бүрэн боловсруулж дуусаагүй байгаа болно. Тавантолгой төмөр зам" ХХК нь 2025 онд "Нексия глобал монголия аудит" ХХК-иар нягтлан бодох
							бүртгэлийн бодлогын баримт бичиг гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан. Ийнхүү тус бодлогын баримт бичигт ерөнхий удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй бодлогыг тусгуулахаар ажиллаж байна. /ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭСЭЭС/
3	Хуулийн байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн насжилт өндөртэй 4 байгууллагын 810.5 сая төгрөгийн авлагад үнэ цэнийн бууралт тооцож, бодит үнэ цэнээр бүртгээгүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"	810,546.10	Авлагыг хэмжих талаар компанийн НБББББ-тээ тусгуулж, авлагын бодит үнэ цэнийг тооцох талаар тусгайлан журам боловсруулан мөрдөх	2025.06.30	СТГ Батжаргал, Дэлгэрхишиг	Авлагыг хэмжих талаар компанийн НБББББ боловсруулж байгаа болно

4	Цаашид ашиглах боломжгүй болсон, гэмтгэх хоцрогдолд орсон 337.1 сая төгрөгийн өртөг бүхий бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолж, тухайн барааны өртөгтэй харьцуулан үнэ цэнийг тогтоож үнэн зөв бүртгээгүй.	НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; 12.2.3.эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед;ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ 31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах 1. Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.	337,147.70	Тайланг хугацааны тооллогыг бодитоор үнэн зөв хийж, хөрөнгийн чанар байдал, ашиглалтыг тодорхойлон илүүдэл дутагдлын шалтгааныг санхүүгийн тайланд тусгадаг байх, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, өртгийг бодитой тогтоож бүртгэлд тусгах талаар ТУЗ-өөр шийдвэр гаргуулах.	2025.06.30	СТГ Э.Дуламсүрэн, Н.Заяа	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТАЗРЫН 2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН 103 ДУГААР ТОГТООЛООР ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЭЦ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авахыг даалгасны дагуу тус тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисст орж компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн тооллогын ажлыг Өмнөговь аймаг Баян-овоо, Цогтцэций, Ханбогд суманд байрлалтай кепл, өртөө, төв оффисийн байрлалд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 02-ны өдрийг дуустал явууллаа. Тайланг бичиж үр дүнг тайлагнаж архивын нэгж үүсгэсэн. Мөн "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/62, А/48 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд
5	Шатахууны норм нормативыг баримтлан зардлыг тооцож, хэмнэлт хэтрэлтийг тодорхойлдоггүй, тусгай зориулалтын машин механизмын шатахуун зарцуулалтын нормыг тусгайлсан журмаар зохицуулаагүй. Шатахууны зардлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй.	12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;	-	Тусгай зориулалттай машин механизмын шатахууны зарцуулалтын нормыг батлан мөрдөж, шатахууны зарцуулалтанд тавигдах хяналтыг сайжруулах.	2025.06.30	СТГ Наранцзэг	Авто машинуудын шатхуун зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсыг үндэслэн зарцуулалтаар нь зардалд бүртгэж банкин дахь шатхууныг бараа материалын үлдэгдлээр тооцон 2024 оны 12 сард зарцуулан бичилт хийсэн. 3ТХСайдын 390-р тушаал болон 2022 онд гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан нормын дагуу 2024 оны хэмнэлт хэтрэлтийг тооцоолж эксель файль бэлдсэн. Захирлын 2024 оны А/100 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдсан. Нормыг шинэчлэхээр ажлын хэсэг байгуулагдаж, зураг авалт хийгдсэн бөгөөд Төлөвлөлтийн хэлтэст төсөл нь бэлтгэгдэн боловсруулагдаж байна. 2022 онд гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан норм, зүтгүүр болон сэрээт, чингэлэг ачигчийн нормыг шинэчлэн батлуулахаар төсөл боловсруулан батлах шатандаа явж байна
6	Батлагдсан орон тоогоор 883 хүн ажиллахаас 2024 оны 6 дугаар сараас 50 орчим гэрээт ажилтныг нэмж ажиллуулж, ажилчдын тоо дунджаар 933 ажилтан болж үр дүн урамшууллыг давхардуулан олгож, цалингийн зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс 1,171.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн.	12.2.3.эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед;ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ 31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах 1. Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.	1,171,030.40	Зардлыг компанийн бүтэц зохион байгуулалттай уялдуулан, өртгийн төв болон зардлын гүйцэтгэлийг бодитоор тооцож төлөвлөх, батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлын гүйцэтгэлийг тайлагнах талаар НБББББ-т тодорхой тусган үнэн зөв, төлөвлөж тайлагнах	2025.06.30	333Х Очхүү,ЗУГ Энхтүвшин Бямбажаргал	Компани нь 2024 оны 12 дугаар сарын байдлаар 785 ажилтантай ажиллаж байна. 2024 оны эхний тоо 688 2024 оны эцсийн тоо 785 Орон тоог нэмэгдүүлэн 16 зүтгүүрийг хүлээн авсантай холбогдуулан Машинч, Туслах машинч, Элгжийн жижүүр-машинч Зааварлагч машинч авч ажиллуулсан. /дэлгэрэнгүйг хавсаргав./
7	Бүртгэлд тусгагдаагүй төслөөс хүлээн авсан хөрөнгийг бусдад түрээслүүлж орлого олж байгаа ч түүнтэй холбоотой зардал бүртгэгдээгүй, мөн түүнээс гадна элэгдлийн зардал бүртгэгдээгүй, мөн түүнээс гадна элэгдлийн зардал бүртгэгдээд байгаа хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй ашиглуулж байгаа ч орлого хүлээн зөвшөөрөөгүй.	НББ тухай хуулийн 5-р зүйл 5.1.6. зохицох зарчим	-	Орлогыг бүртгэсэн цаг хугацаанд тухайн орлогыг олохтой холбоотой гарсан зардлыг хүлээн зөвшөөрч байх, орлого зардлыг бүртгэж тайлагнахдаа НББ-ийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг баримталж ажиллах	2025.06.30	ТУГ Батбаяр, СТГ Э.Амарсайхан, Ч.Чаналнсов	Тайланг хугацааны түрээсийн орлогуудыг холбогдох гэрээ, баримтуудыг үндэслэн үүсгэж, уг үйл ажиллагаатай холбогдон гэрч байгаа зардлуудыг ББӨ-р тооцон ажиллаж байна. Компанийн балансад бүртгэлтэй ачааны хагас вагон 100 ширхэг 39659930194.73 төгрөгийн балансын үнэ, 5820055420.00 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, ачааны тавцант вагон 200 ширхэг 9915882607.66 төгрөгийн балансын үнэ, 8591063136.00 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй байна. Бүртгэлд тусгаагүй хөрөнгөд элэгдэл тооцоогүй

8	Худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулахдаа шаардлагатай хөрөнгийн үлдэгдэл буюу төслийн хүрээнд хүлээн авсан хөрөнгийн бүртгэл байхгүйгээс шаардгдах хөрөнгө, бараа материалын хэрэгцээнд үндэслэн төлөвлөж байгаа нь тухайн хөрөнгө, барааг давхардуулан авахаар төлөвлөх эрсдэл үүсч болзошгүй байна. Төслийн хөрөнгийг баланс болон балансаас гадуур бүртгээгүй тул худалдан авалтын төлөвлөлтийг үнэн зөв хийгдсэн эсэхэд учир дутагдалтай	ТБОНӨБАҮХАТХ 5.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.47.2.2.икил төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх боломжтой бол.48.2.8.энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;		Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөхийн тулд байгууллагын хэмжээнд хэрэглэх хөрөнгө, бараа болон ажил үйлчилгээний жагсаалтыг бодитоор гарган дүгнэж байх	2025.06.30	ХААХ Марс-Сд, Батсолонго, СГТ Цэрэндүг, Э.Амарсайхан, Ч.Чанцалнорж	Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.
9	Шилэн дансны цахим хуудсанд оруулсан холбогдох мэдээллийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн зардлын 547 мэдээлэл байршуулахаас 527 мэдээллийг байршуулж, 20 мэдээлэл буюу 5,724,864.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой 2, бусад асуудалтай холбоотой 1 нийт 5 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулах		Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод тогтоосон хугацаанд тогтмол байршуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2025.06.30	НББХ, ТХ, ХААХ, ЗЭЗХ	Шилэн дансны хуулийн дагуу 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг тогтмол мэдээллэн, алдааг дахин дастан гаргахгүй байхаар ажиллаж байна.

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС